

САНХҮҮГИЙН ЗОХИЦУУЛАХ ХОРООНЫ ТОГТООЛ

2010 оны 4 дүгээр
сарын 28-ны өдөр

Дугаар 130

Улаанбаатар хот

Г “Алтан тариа” ХК-ийн талаар Ү
авч хэрэгжүүлэх арга хэмжээний тухай

Санхүүгийн зохицуулах хорооны эрх зүйн байдлын тухай хуулийн 4.1, 6.1.1, 6.2.2, Үнэт цаасны зах зээлийн тухай хуулийн 34.1.1 дэх заалт Компанийн тухай хуулийн 54, 55, 56 дугаар зүйл, Санхүүгийн зохицуулах хорооны дэргэдэх Хяналтын зөвлөлийн 2010 оны 4 дүгээр сарын 09-ний өдрийн хуралдааны 03 дугаар тэмдэглэлийг тус тус үндэслэн Санхүүгийн зохицуулах хорооноос ТОГТООХ нь:

1. “Алтан тариа” ХК хэлбэрээ өөрчлөн “Алтан тариа” ХХК болохыг зөвшөөрч Улсын бүртгэлд бүртгэсэн шийдвэрийг хүчингүй болгох талаар шүүхэд нэхэмжлэл гаргаж зохих ажиллагааг шуурхай гүйцэтгэхийг Эрх зүйн хэлтэс /О.Батбилэг/, Үнэт цаасны газар /Э.Ганбат/-т тус тус үүрэг болгосугай.

2. Холбогдох хууль тогтоомжоор хүлээсэн үүргээ биелүүлж ажиллаагүй “Алтан тариа” ХК-ийн хувьцааг үнэт цаасны бүртгэлээс хасах боломжгүй тухай тус компанийн удирдлагад мэдэгдэхийг Үнэт цаасны газар /Э.Ганбат/-т үүрэг болгосугай.

3. Тогтоолын биелэлтэд хяналт тавьж ажиллахыг Ажлын алба /Х.Бум-Эрдэнэ/, олон нийтэд мэдээлэхийг Тамгын газар /Н.Удаанжаргал/-т тус тус даалгасугай.

ДАРГА

Д.БАЯРСАЙХАН